

Залуучууд, насанд хүрэгчдийн боловсрол хариуцсан арга зүйч, мэргэжилтэн Энхжаргал Золзаяа

2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
			1	2	3	4	5
1.1. Үндэсний хэмжээнд залуучууд, насанд хүрэгчдийн боловсролыг дэмжих үйл ажиллагааны эрх зүйн орчныг бүрдүүлэх бодлого, шийдвэрийн төсөл, санал боловсруулах							
1	Залуучууд насанд хүрэгчдийн боловсролыг дэмжих чиглэлээр үндэсний хэмжээнд тогтмол судалгаа хийх	Үндсэн чиглэлийн сургалтад хамрагдсан хүний тоон мэдээлэл, судалгааг эхний хагас жил болон жилийн эцсийн байдлаар Насан туршийн суралцахуйн төвөөс 2 удаа авч нэгтгэх, танилцуулах	2024 онд жилийн эцсийн тоон мэдээллийг нэгтгэж, танилцуулсан.	1	Аймаг, дүүргийн Насан туршийн суралцахуйн 30 төваас сургалт үйл ажиллагааны тайланг авч нэгтгэсэн ба улсын хэмжээнд 2025 оны эхний хагас жилийн байдлаар иргэдийн боловсролыг дэмжих чиглэлээр 11059 удаагийн сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 483798 иргэн хамрагдсан байна. Доорх тоон мэдээ нь 2024-2025 оны хичээлийн жилийн зорилго зорилтын биелэлтэд Боловсролын яам руу нэгтгэн явуулсан тоон мэдээ ба хавсралтад нийт сургалтын тоон мэдээг	5-р сар, 11-р сар	100%

				хавсаргасан болно. Гэр бүлийн боловсрол – 68 төрлийн 1980 удаагийн сургалтад 113404 иргэн, 28 төрлийн 1189 удаагийн нөлөөллийн үйл ажиллагаанд 60586 иргэн; Иргэний боловсрол – 1574 удаагийн сургалтад 57645 иргэн, 514 удаагийн нөлөөллийн ажилд 31690 иргэн; Ёс суртхуун төлөвшлийн боловсрол - 1471 удаагийн сургалтад нийт 49781 иргэн, 817 удаагийн нөлөөллийн ажилд 83,713 иргэн; Гоо зүй-мэдрэмжийн боловсрол - 1341 удаагийн сургалтад нийт 32698 иргэн, 682 удаагийн нөлөөллийн ажилд 33579 иргэн; Амьдрах ухааны боловсролын 13 модулиар 984 удаагийн сургалтад 124640 иргэн тус тус хамрагдсан байна. Гадаад хэлний боловсрол - 864 удаагийн сургалтад нийт 11402 иргэн; Санхүүгийн боловсрол - 1031 удаагийн сургалтад нийт 40,806 иргэн, 491 удаагийн нөлөөллийн ажилд 41238 иргэн; Тогтвортой хөгжлийн боловсрол - 630 удаагийн сургалтад нийт 23642 иргэн, 696 удаагийн нөлөөллийн ажилд 47969 иргэн; Мэдээлэл технологийн	
--	--	--	--	---	--

					боловсрол -1184 удаагийн сургалтад нийт 29780 иргэн тус тус хамрагдсан байна. Жич: Энэ жилээс тоон судалгаа авах маягыг илүү нарийвчлан мэдээллийг авсан ч эргээд нэгтгэх тал дээр учир дутагдалтай зүйлс их тулгарлаа. Тайлан бүрийг нэг бүрчлэн шивж оруулах нь цаг их алдаж байгаа тул оны эцсийн тайланг авахдаа маягыг дахин боловсронгуй болгох илүү хялбар байдлаар ажиллагааг сайжруулахад анхаарч ажиллана.		
					Хавсралт: 2 файл		
2	Залуучууд, насанд хүрэгчдийн боловсролыг дэмжих үйл ажиллагааны эрх зүйн орчныг бүрдүүлэхэд бодлого, шийдвэрийн төсөл, санал боловсруулах	Санал өгсөн баримт бичгийн тоо	2024 онд 1 баримт бичигт санал өгсөн.	-	Залуучууд насанд хүрэгчдийн боловсролын судалгаа мэдээлэл нэгтгэх тоон тайлан авах маягт шинэчлэхэд 2025 оны 4 сарын 21-ний өдөр санал өгсөн. Шинэчлэгдсэн маягт нь нэгтгэхэд төвөгтэй нэг бүрчлэн шивж оруулах гэх мэт алдаа дутагдал их байгаа тул оны эцсийн тайланг авахдаа дахин шинэчлэн саналтай байна.	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
					Хавсралт: 2 файл		

1.2. Үндэсний хэмжээнд хийгдэж буй залуучууд, насанд хүрэгчдийн боловсролыг дэмжих салбар дундын бодлого төлөвлөлт, менежментэд зохицуулалт хийх, бодлогын хэрэгжилт, чанар, үр дүнг тооцох, залуучууд, насанд хүрэгчдийн чиглэлээр хийгдэж буй дэмжих үйл ажиллагааг олон улсын насан туршдаа суралцахуйн чиг хандлагад нийцүүлэн хөгжүүлэх, агуулга, арга зүй, менежментийг боловсронгуй болгох, хэрэгжүүлэх

3	Аймаг, дүүрэг, сумдын Насан туршийн суралцахуйн төвийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, зөвлөн туслах	Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн байгууллагын тоо	2024 онд 4 төвд зөвлөн тусалсан.	2	1. Баянхонгор аймгийн Насан туршийн суралцахуйн төвийн үйл ажиллагаатай, орчин нөхцөлтэй танилцсан. 2025 оны 5 дугаар суран 15 болон 23-ны өдөр очиж танилцсан. Тус төвийн 2025 оны 5 дугаар сарын 23-ны өдөр аймгийн тангын газрын хурлын зааланд зохион байгуулсан ахмадуудад цахим орчинд ажиллаж сурах сургалтын үйл ажиллагаанд мөн оролцсон. Баянхонгор аймагт байрлах төв нь Боловсролын газартайгаа хамт нэг байранд байрладаг ба байрын орчин нөхцөл хуучин, засвар хийх зайлшгүй шаардлагатай. Анги танхимын тохижилт, ширээ сандал болон компьютер техник хангамжийг шинэчлэх нэн шаардлагатай дүр зурагтай байв. Хэдий тийм ч орон нутгийн хэмжээнд зохион байгуулж буй сургалт болон нөлөөллийн ажлыг маш сайн хийдэг тухай захирал болон төвийн хамт олон хэлсэн юм. 2. Мөн Увс аймаг, Дорнод аймаг, Орхон аймгуудад тус тус тНасан туршийн суралцахуйн төвийн үйл ажиллагааны үр дүн, тайлагнах явцын тайланд	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
---	---	---	----------------------------------	---	--	---	------

				мэргэжил арга зүйн зөвлөн туслах үйлчилгээг цахим болон утсаар холбогдон үзүүлж хамтарч ажиллалаа. 3. 2025 оны 5 сарын 5-ны өдрийн БЕГ-ын даргын 1/1613 тоот албан бичгийг 21 аймаг 9 дүүргийн Насан туршийн суралцахуйн төвд хүргүүлсэн. Тус бичиг нь Малчин өрхийн гишүүний сургалт, боловсролыг дэмжих арга хэмжээг дэмжин хамтарч ажиллах, биелэлтийг тайлагнаж ажиллах тухай удирдлагуудын цахим хуралд ппт бэлтгэн танилцуулж зөвлөн тусалж ажилласан. 4.Боловсролын ерөнхий газрын даргын 2025 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн Б/102 тушаалын хэрэгжилтийн дагуу Баян-Өлгий, Увс аймаг, Багануур дүүргийн Насан туршийн суралцахуйн төвийн гүйцэтгэлийн 1-р улирлын тайланг үнэлэн дүгнэж, цаашид тайлан хийхэд анхаарах зүйлийг зааварчлан, зөвлөн тусалж дэмжлэг үзүүлж ажилласан. Дүгнэлттэй холбоотой файлыг хавсаргав. 5. Олон улсад Насан туршийн боловсрол хэрхэн хэрэгжиж буй талаар болон Монгол улстай харьцуулсан	
--	--	--	--	---	--

					мэдээлэл ппт бэлтгэв. Хавсралтад хавсаргав. Хавсралт: 14 файл		
4	Насан туршийн суралцахуй, насанд хүрэгчдийн боловсролыг дэмжих чиглэлээр төрийн, төрийн бус байгууллагатай хамтран ажиллах	Хамтран ажилласан байгууллагын тоо	2024 онд 2 байгууллага-тай хамтран ажилласан	1	Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр "Мэдлэ" цахим сургуультай хамтран зохион байгуулж буй "Багшийн цахим ур чадварыг дээшлүүлэх хосолсон сургалтын арга зүй" сургалтын бэлтгэл ажлыг ханган, сургалтыг 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлүүлж 5 сарын хугацаанд багш нар ур чадвараа сайжруулсан. Нийт 573 багш хамрагдахаас 6 бүсэд нийт мэргэжилтнүүд хугаан авч тухайн багш нарыг хариуцан ажилласан ба миний бие 4-р бүс буюу Говь-Алтай аймаг, Дорнод аймаг, Баянзүрх дүүрэг, Чингэлтэй дүүрэг, Баянгол дүүрэг, Хан-Уул дүүргийн 6 төвийн нийт 92 багшийг хамруулсан. Хавсралт: 2 файл	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
5	Суралцагч аймаг дүүргийн сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, туршлага солилцох үйл ажиллагааг зохион байгуулах	Сайн туршлагыг түгээн дэлгэрүүлсэн төвийн тоо	2024 онд 2 төвийн туршлага солилцсон.	1	2025 оны эхний хагас жилийн байдлаар Суралцагч аймаг дүүргийн сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх туршлага солилцох үйл ажиллагааг зохион байгуулах чиглэлээр Орхон, Сэлэнгэ, Увс аймгийн	3-р сар, 4-р сар, 5-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар	100%

					Насан туршийн суралцахуйн төвөөр дамжуулан сургалтад хамрагдсан иргэд, төвийн үйл ажиллагааны талаарх сайн туршлагыг видео хэлбэрээр Боловсролын ерөнхий газрын цахим хуудсаар дамжуулан 2025 оны 6 дугаар сарын 2, 3, 4-ний өдрүүдэд тус тус түгээсэн. Тус бичлэгт Малчин өрхийн боловсрол сургалтыг дэмжих арга хэмжээний чиглэлээр хамрагдсан иргэдийн мэдээлэл туршлагын талаар мэдээлсэн. Мөн иргэдийн насан туршдаа суралцахуйг дэмжих чиглэлээр үйл ажиллааны талаар мэдээллийг тус тус оруулсан болно. Цахим орчинд оруулснаас хойш 2 өдрийн дотор Орхон аймгийн Насан туршийн суралцахуйн төвийн сайн туршлага -2800 гаруй хүний хандалттай, Сэлэнгэ аймгийн Насан туршийн суралцахуйн төвийн сайн туршлага-4400 гаруй хүний хандалттай байна. Хавсралт: 2 файл		
6	Залуучууд насанд хүрэгчдийн чиглэлийн насанд үндсэн боловсрол	Зохион байгуулсан сургалт, үйл ажиллагааны тоо	Залуучууд насанд хүрэгчдийн	1	1. НҮБ-ын Хүн амын сантай хамтран хүний Папилома вирус, өвчлөлийн шалтгаан,	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р	100%

	олгох багш нарын ур чадварыг сайжруулах, хүний нөөцийг чадавхжуулах танхим/цахим хосолсон сургалт зохион байгуулах		боловсрол олгох чиглэлээр 70 багш	халдварын эсрэг дархлаажуулалт болон вакцины талаарх буруу ташаа ойлголтыг залруулах, сүүлийн үеийн мэдээлэл өгөх сургалтыг нийслэлийн 9 дүүргийн Насан туршийн суралцахуйн төвийн багш, удирдах ажилтнуудад 2025 оны 3 дугаар сарын 11-ний өдөр НҮБ-ийн байранд зохион байгуулсан. Уг сургалтаар иргэдийн эрүүл мэндийн боловсролын чадвааыг дээшлүүлэх чиглэлийн хүрээнд үндсэн чиглэлийн эрүүл мэндийн боловсрол олгох багш нарт эрүүл мэндийн боловсролын талаарх ойлголт, өнөөгийн байдал, өмнөх жилүүдэд энэ чиглэлээр манай төвүүдэд хийгдэж байсан сургалтын хөтөлбөрт ашиглагдаж байсан гарын авлага, модулуудыг танилцуулсан ба эрүүл мэндийн боловсрол олгох багш нарт тавигдах багшийн ёс зүй, суралцагчидтай харилцах арга зүйн талаар слайд мэдээллийг бэлтгэж сургагч багш нарыг мэдээллээр ханган ажиллсан. Тус сургалтад 9 дүүргийн 55 багш, удирдах ажилтан хамрагдав. 2. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Насан	сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	
--	---	--	--	--	--	--

				туршийн суралцахуйн төвийн багш, удирдах ажилтны цахим ур чадварыг дээшлүүлж, цахим сургалт зохион байгуулах арга зүй, ур чадварыг сайжруулах зорилгоор “Мэдлэ” цахим сургуультай хамтран “Хосолсон сургалтын арга зүй сургалт”-ыг 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлэн 6 сарын хугацаанд 21 аймаг, 9 дүүргийн НТСТ-ийн нийт 573 багш, удирдах ажилтан хамрагдаж байна Энэхүү цахим сургалтад хамрагдсанаар багш, удирдах ажилтнууд хосолсон сургалтын арга зүйн шийдэл, цахим сургалтын талбар бэлтгэх, цахим сургалт зохион байгуулах арга зүй, ур чадвараа дээшлүүлсэн ба миний хариуцсан 4-р бүсээс нийт 92 багш хамрагдахаас 87 багш хамрагдаж 5 багш нь тухайн хугацаанд тэтгэвэрт гарах болон ажлаа сольсон учир энэ сургалтад бүрэн хамрагдаж чадаагүй. Хамрагдсан 87 багшийн 73 нь 89,9% батламж авах эрх үүссэн ба 14 багш буюу 16% нь батламж аваагүй үзүүлэлттэй гарсан. Хавсралт: 7 файл	
--	--	--	--	--	--

3.1. Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах

7	ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх	Биелэлтийн хувь	2024 оны жилийн эцсийн үнэлгээ 81.75%	100%	ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлж ажилласан. 1. Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын 2.2, 2.4, 4.1 дэх заалтын дагуу төрийн албан хаагчийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулав. 2. Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын 2.2, 2.4, 4.1 дэх заалтын дагуу төрийн албан хаагчийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
---	--	-----------------	---------------------------------------	------	--	---	------

					шинэчлэн, боловсруулж батлуулав. 3. Ерөнхий боловсролын сургуулийн гүйцэтгэлийн үнэлгээгээр Баянхонгор аймгийн Баянхонгор сумын Гэгээн сумад сургууль дээр ажилласан ба 41 багшийн үнэлгээг амжилттай зохион байгуулсан. Үнэлгээний түүвэрт нийт 1147 суралцагч түүвэрлэгдсэнээс шалгалтад 1139 суралцагч хамрагдаж ирц 99,3 хувьтай байна. Шалгалтад хамрагдаагүй 4 суралцагч байна. Үүнээс өвчтэй-3 /4/, чөлөөлтэй-1 /4/ суралцагч байсан. Түүвэр шалгалтад давхардаж орсон тоог хаалтад оруулсан болно. Хавсралтад тус сургууль дээр ажилласан тайланг оруулсан. Хавсралт: 1 файл		
8	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс	Биелэлтийн хувь	2024 оны жилийн эцсийн үнэлгээ 81.75%	100%	1. 2025 оны Боловсролын ерөнхий газрын даргын 1/1664, 1/1613, 1/1588, 1/1413 тоот нийт 4 албан бичгийг тус тус боловсруулан аймаг дүүргийн Насан туршийн суралцахуйн төв, 21 аймгийн Засаг даргын тамгын газарт тус тус явуулсан. 2. 2025 оны 5 дугаар сарын 8-ны өдөр архивт Насан туршийн суралцахуйн төвийн Бүсийн	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

	урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх				сургалтын тайланг архивийн нэгж болгон архив бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгсөн. 3. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлсэн. Хавсралт: 1 файл	
--	--	--	--	--	--	--

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7

4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх

1	Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх	Хүний нөөцийн хөгжлийг дэмжих чиглэлээр байгууллагаас зохион байгуулж буй сургалт, уулзалтад хамрагдах	2 сургалтад хамрагдсан	1, 2	1.Боловсролын Дэлхийн түншлэл олон улсын байгууллагын санхүүжилтээр хэрэгжүүлж буй "Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих төсөл"-ийн хүрээнд Боловсролын яам, харьяа байгууллагын албан хаагч нарт зориулсан "Монгол дохионы хэлний харилцааны анхан шат"-ны мэдлэг олгох 30 цагийн сургалтад 2025 оны 4 сарын 30-ны өдрөөс 4 өдрийн турш бүтэн хамрагдсан. 2. Нийгмийн даатгалын ерөнхий газраас зохион байгуулсан Нийгмийн даатгалын шимтгэл төлөлт, нийгмийн даатгалтай холбоотой шинэ хуулийн заалт өөрчлөлт, тэтгэвэрт гарахтай холбоотой баримт бичгийн бүрдүүлэлт, лавлагаа мэдээлэл уулзалт сургалтад 2025 оны 5 сарын 8-ны өдөр тус тус хамрагдсан. 3. Бүгд Найрамдах Солонгос улсын Seoul, Seongnam, Gyeongido хотуудад Солонгосын боловсролын цахим сургалтын сайн туршлага судлах, сургалт семинарт 2025 оны 03 сарын 24-ний өдрөөс 29-ний өдрүүдэд зохион байгуулагдсан ба тус арга хэмжээний хүрээнд Инчеон хотын Байгалийн	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
---	--	--	------------------------	------	--	--	------

					шинжлэх ухааны парк мөн БНСУ-ын Woongjin сурах бичгийн компани, NAVER компани, EdTech компаниудын үйл ажиллагаатай танилцаж, сургалт, мэдээлэлд хамрагдсан. Туршлага судлах өөр орны хүүхдүүдийн суралцах арга барил, тэдгээр хүүхдүүдэд зориулсан сургалтын хөтөлбөр, агуулга хэрхэн бүтдэг талаар маш сонирхолтой мэдээллүүдийг олж авсан нь үнэлж баршгүй баялаг байлаа. Солонгос улс нь хүүхдүүдийнхээ англи хэлний чадвар болон шинжлэх ухаан, техник технологийн хөгжил, үүсэл гарал зэрэг хичээлийн мэдээллүүдийг хүүхдүүдэд маш сонирхолтой хэлбэрээр ойлгуулах технологийг бүтээсэн нь үнэхээр бахархмаар, цаашид бид ч бас үүнийг өөрийн орны хэл соёлын онцлогт тохируулан сайн туршлагыг дэлгэрүүлмээр санагдлаа. Сургалт семинар, туршлага солилцох ажлын зураг болон бичлэг бүхий мэдээллийг хавсралтаар оруулав. 4. НҮБ-ХАС ЭМЯ-с Вакцинжуулалттай холбоотой асуудлаар сургалтад сууж	
--	--	--	--	--	---	--

					хувь хүний вакцины тухай мэдлэгээ дээшлүүлэв Хавсралт: 10 файл		
2	Монгол бичгийн мэдлэг ур чадвараа дээшлүүлэх	Монгол бичгийн мэдлэг ур чадвараа дээшлүүлэх, анхан шатнаас дунд түвшинд хүрэхэд бие даан суралцах /Төрийн албан хаагчдад зориулсан Монгол бичгийн гарын авлага-1 Б.Золжаргал 2023 оны номын анхан болон дунд шатны хичээлийг үзэж судлах	-	Монгол бичгийн гарын авлага-1 Б.Золжаргал 2023 оны номын 5-р бүлэг 1-45р хуудсыг уншиж, судалсан байна.	Монгол бичгийн ур чадвараа дээшлүүлэх, анхан шатнаас дунд түвшинд хүрэхэд бие даан Монгол бичгийн гарын авлага-1 Б.Золжаргал 2023 оны номын 5-р бүлэг 1-45-р хуудсыг уншиж судалсан. Хичээлийг үзэж судалсан тэмдэглэл дэвтрийг хавсаргав. Хавсралт: 1 файл	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11- р сар, 12-р сар	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Залуучууд, насанд хүрэгчдийн боловсрол хариуцсан арга зүйч, мэргэжилтэн, Энхжаргал Золзаяа /...../
Огноо: